

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон  
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Орхон аймгийн Боловсрол, соёл урлагийн газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Уурхайчин" баг, Захиргааны 4-р байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй


### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, бага боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж, хяналт тавих, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Боловсрол, соёл урлагийн газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Боловсролын талаар төр, орон нутгаас баримтлах бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах.
2. Бага боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд багш, удирдах ажилтан, иргэн хуулийн этгээдэд чиглэсэн үйлчилгээ, мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх, лавлагаа, зөвлөмж, мэдээллээр хангах.
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Боловсролын тухай хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, шийдвэрийг байгууллага, олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах.	Хууль тогтоомж бусад дүрэм, журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г
	2.Боловсролыг хөгжүүлэх орон нутгийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.	Тайлан, бүртгэл, судалгааг цаг хугацаанд гаргасан байна.	Г
	3.Багш, удирдах ажилтан, иргэн хуулийн этгээдэд чиглэсэн үйлчилгээ, мэргэшил арга зүйн туслалцаа үзүүлэх, лавлагаа, зөвлөмж, мэдээллээр хангах.	Багш, удирдах ажилтан, иргэн хуулийн этгээд мэдээллээр хангагдсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Бага боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр арга зүй, технологи хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг мэдээллээр хангах, санал боловсруулах. 2.Суралцагчийн хэрэгцээ сонирхол, сургуулийн нөхцөл байдал, багшийн ур чадварт тулгуурлан орон нутгийн түвшний болон гүнзгий сургалтын	Бага боловсролын үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай үзүүлсэн байна.  Стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөг	Г 



	<p>хөтөлбөр боловсруулах, турших, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт санал өгөх.</p> <p>3.Сургалтын орчин бүрдүүлэлт, тоног төхөөрөмжийн ашиглалт, сурах бичиг, гарын авлагын хангалт, ашиглалтад хяналт тавих.</p> <p>4.Багш, удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шагналд тодорхойлох асуудалд санал өгөх.</p> <p>5.Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцох.</p>	<p>амжилттай хэрэгжүүлсэн байна.</p> <p>Сургалтын орчин сайжирна.</p> <p>Багш, удирдах ажилтны мэдлэг, үр чадвар сайжирна.</p> <p>Сурлагын чанар сайжирна.</p>	<p>Г</p> <p>Г, Х</p> <p>Г</p> <p>Г, Х</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах.</p> <p>2.Төрийн албаны болон Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах.</p> <p>3.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх</p> <p>4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах.</p> <p>5.Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг ханган ажиллах.</p> <p>6.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх.</p> <p>7.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.</p> <p>8.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах.</p> <p>9.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж</p>	<p>Хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>



хэрэгжүүлэх, тайлагнах.		
-------------------------	--	--

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	бага боловсролын багш мэргэжилтэй байх	
Мэргэшил	<ul style="list-style-type: none"> <li>- төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх;</li> <li>- мэргэжлийн "Заах аргач" болон түүнээс дээш зэрэгтэй байх.</li> </ul>	
Туршлага	Туслах түшмэлийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;</li> <li>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;</li> <li>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;</li> <li>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;</li> <li>- хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;</li> <li>- бүтээлч, санаачлагатай ажиллах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> <li>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- нээлттэй шударга байх;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх,</li> <li>- зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;</li> <li>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> </ul>



– англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.

**IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:  
Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй

Бусад харилцах субъект :

- ЕБС-ийн захирал, сургалтын менежерүүд
- ЕБС-ийн бага ангийн багш
- нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын холбогдох ажилтан
- төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Ч.Сэржнагар* Ч.СЭРЖНАГАР

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19 10 23

Дугаар: 147

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан**

Байгууллагын нэр:

ОРХОН АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 19 10 30

Дугаар: 5/17

(тамга/тэмдэг)

ДАРГА ..... Ж.БАТ-АМГАЛАН

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2019 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

